

ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааны үр дүнд тулгуурлан дээд боловсролын салбарын хөгжилд хувь нэмэр оруулах зорилгоор сэдэвчилсэн дүн шинжилгээ хийж, бодлогын зөвлөмж боловсруулах, түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд магадлан итгэмжлэлийн үнэлгээний үр дүнг нэгтгэн боловсруулж, салбарт тулгамдаж буй асуудал, сайжруулах шаардлагатай чиглэлүүд, түүнчлэн сайн туршлагыг тодорхойлон дээд боловсролын байгууллагуудын тасралтгүй сайжруулалтад дэмжлэг үзүүлж байна.

Тухайлбал, Дээд боловсролын сургалтын байгууллагын 2024, 2025 онуудад хуучин болон шинэ шалгуураар тус бүр 21, нийт 42 сургалтын байгууллага, 2024 онд магадлан итгэмжлэгдсэн 109 бакалаврын хөтөлбөр, Мэргэжлийн болон техникийн боловсролын 2025, 2026 онд шинэ шалгуур шаардлагаар магадлан итгэмжлэгдсэн 27 хөтөлбөрийн шинжээчийн үнэлгээ, дүгнэлт болон магадлан итгэмжлэх комиссын тогтоолоор гарсан зөвлөмж, шаардлагад тоон болон чанарын дүн шинжилгээг хийсэн. Уг шинжилгээг SURE үнэлгээний бүтэц болон SPSS 25.0 программ ашиглан боловсруулж, үр дүнг нэгтгэн дүгнэсэн бөгөөд энэ нь салбарын шинжээчид, оролцогч талуудын санал, туршлагыг системтэйгээр нэгтгэх боломжийг бүрдүүлсэн.

Мөн дүн шинжилгээний үр дүнд үндэслэн сургалтын байгууллагуудын анхаарах шаардлагатай асуудлуудыг тодорхойлж, шинжээчийн зөвлөмж, шаардлагын уялдаа холбоо, хамаарлыг харьцуулсан дүгнэлтүүдийг гаргасан. Эдгээр үр дүнг магадлан итгэмжлэх комиссын гишүүд болон эрх бүхий шинжээчдийг чадавхжуулах сургалт, их дээд сургуулиудад зориулсан сургалт, арга хэмжээгээр дамжуулан түгээн дэлгэрүүлж, хамтын ажиллагааг бэхжүүлэн ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд мэргэжлийн чиглэл тус бүрээр нарийвчилсан сургалтыг 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрөөс 12 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл зохион байгуулж, шинжээчид болон комиссын гишүүдийн үнэлгээ хийх чадавхыг нэмэгдүүлэх, чанарын баталгаажуулалтын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэн ажиллаж байна.

2025-2026 оны байдлаар Монгол Улсад 68 дээд боловсролын байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас 54 нь магадлан итгэмжлэгдсэн бөгөөд нийт суралцагчдын 79.4 хувь нь магадлан итгэмжлэгдсэн сургуульд суралцаж байна.

Хуучин шалгуураар үнэлэгдсэн байгууллагуудын дундаж үнэлгээ 96.8 хувь байсан бөгөөд “эрдэм шинжилгээ, судалгаа” хамгийн сул, “нийгэмд чиглэсэн үйлчилгээ” хамгийн өндөр үнэлгээтэй гарсан. Шинэ шалгуураар үнэлэгдсэн байгууллагуудын дундаж үнэлгээ 91.8 хувь байсан ба “чанарын баталгаажуулалт”, “эрдэм шинжилгээ, инноваци” хамгийн сул үнэлгээтэй гарсан. Дотуур байр, санхүүгийн эх үүсвэр, судалгааны төсөв, оюуны өмчийн хамгаалалт, чанарын дотоод баталгаажуулалт, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөх байдал зэрэг үзүүлэлтүүд хамгийн бага үнэлгээ авсан. **(Хавсралт 01.)**

Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг 2004 оноос хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2025–2026 оны байдлаар нийт 978 хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэнээс 526 хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хүчинтэй байна.

2024 онд 108 бакалаврын хөтөлбөрт хийсэн шинжилгээгээр шалгуур шаардлагын хэрэгжилтийн дундаж үнэлгээ 95.8 хувь гарсан байна. “Багшийн үйл ажиллагаа”, “чанарын үнэлгээ, баталгаажуулалт” хамгийн бага үнэлгээтэй байсан бол “суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа”, “хөтөлбөрийн төлөвлөлт” хамгийн өндөр үнэлгээтэй гарсан.

Шинжээчдийн өгсөн 2400 зөвлөмж, 182 шаардлагад агуулгын шинжилгээ хийж, дараах нийтлэг асуудлуудыг тодорхойлсон.

- Хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүнг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах шаардлагатай;
- Практик болон судалгаанд суурилсан сургалтын арга зүй сул;
- Дадлага, үйлдвэрлэлийн орчны хүртээмж хангалтгүй;
- Багшийн судалгааны бүтээмж, олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатай;
- Дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоо сул байна. **(Хавсралт 02.)**

2025-2026 оны байдлаар Монгол Улсад мэргэжлийн болон техникийн боловсролын 70 байгууллага үйл ажиллагаа явуулж, 41584 суралцагч суралцаж байна. Нийт 1096 хөтөлбөр хэрэгжиж байгаагаас 82 хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн байна.

Шинжилгээгээр шалгуур шаардлагын хэрэгжилтийн дундаж үнэлгээ 92 хувь гарсан бөгөөд зайны болон цахим сургалтын технологийн нөхцөл, цахим мэдээллийн хүртээмж, судалгаа инновацийн дэмжлэг хамгийн сул үнэлгээтэй байв.

Шинжээчдийн өгсөн зөвлөмж, шаардлагад агуулгын шинжилгээ хийж, дараах нийтлэг асуудлуудыг тодорхойлсон.

- Хөтөлбөрүүдийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, технологийн өөрчлөлттэй уялдуулан шинэчлэх шаардлагатай;
- Цахим сургалт, зөөлөн ур чадвар, шинэ технологийн агуулгыг нэмэгдүүлэх хэрэгцээтэй;
- Лаборатори, дотуур байр, сургалтын орчны чанар, аюулгүй байдлыг сайжруулах шаардлагатай;
- Багшийн цахим болон мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх хэрэгцээ өндөр;
- Суралцагчийн сэтгэл зүйн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ сул байна.

(Хавсралт 03.)

Эдгээр шинжилгээний үр дүнгээс харахад Монгол Улсын боловсролын салбарын чанарын баталгаажуулалтын тогтолцоо тодорхой ахицтай байгаа боловч дотоод чанарын удирдлага, судалгаа инноваци, цахим шилжилт, хөдөлмөрийн зах зээлтэй уялдсан сургалтын бодлого, хүний нөөцийн хөгжил зэрэг чиглэлд цаашид системтэй шинэчлэл хийх шаардлага өндөр хэвээр байна. Иймээс Боловсролын яам, БМИҮЗ болон сургалтын байгууллагуудын хамтын ажиллагаанд тулгуурласан тасралтгүй сайжруулалтын тогтолцоог бэхжүүлэх нь чухал байна.

Хавсралт 01.**1. Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын баталгаажуулалтад хийсэн шинжилгээний үр дүн**


Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь Монгол Улсад сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа сургалтын байгууллагуудын үйл ажиллагаа, чанар үр дүнг хүлээн зөвшөөрөх магадлан итгэмжлэх үйл ажиллагааг 1998 оноос эхлэн хийсэн.

Монгол Улсын хэмжээнд 2025-2026 оны хичээлийн жилд сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 68 дээд боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс их сургууль 46, коллеж 22, төрийн өмчийн 17, төрийн бус өмчийн 51 сургууль үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр сургуулиудад 2274 хөтөлбөр хэрэгжиж нийт 165 мянга гаруй оюутан суралцаж байна.

Он	Магадлан итгэмжлэгдсэн				Тухайн онд магадлан итгэмжлэгдсэн сургууль	Нийт магадлан итгэмжлэгдсэн сургуулийн тоо
	Анх удаа	Хоёр дахь удаа	Гурав дахь удаа	Дөрөв дэх удаа		
1999	14	-	-	-	14	14
2000	6	-	-	-	6	20
2001	10	-	-	-	10	30
2002	10	-	-	-	10	40
2003	16	-	-	-	16	56
2004	14	9	-	-	23	68
2005	15	6	-	-	21	85
2006	7	12	-	-	19	88
2007	5	7	-	-	12	88
2008	8	8	-	-	16	91
2009	-	11	-	-	11	86
2010	-	6	-	-	6	86
2011	2	9	-	-	11	68
2012	4	3	-	-	7	67
2013	-	3	-	-	-	70
2014	3	5	-	-	8	63
2015	-	-	-	-	-	63
2016	-	-	-	-	-	63
2017	-	-	-	-	-	63
2018	3	1	19	-	23	73
2019	4	9	14	-	27	77
2020	2	3	3	-	8	82
2021	2	1	4	-	7	81
2022	1	-	4	-	5	81
2023	-	1	1	2	4	63
2024	1	5	6	16	28	62
2025	1	3	1	8	13	54

2025-2026 оны хичээлийн жилийн 2-р улирлын байдлаар Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын баталгаажуулалтын хувьд магадлан итгэмжлэгдсэн 54,

магадлан итгэмжлэлийн процесс явагдаж байгаа 9, хойшлуулах шийдвэр гарсан 1, магадлан итгэмжлэгдээгүй 4 сургалтын байгууллага байна.



ДБСБ-ын 54 байгууллага магадлан итгэмжлэгдсэнээр нийт суралцагчдын 79.4% нь магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуульд суралцаж байна.

Монгол Улсын Консерваторийн харьяа Завхан аймаг дахь Хөгжим, бүжгийн коллеж болон ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль нь МУЗГ-ын 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 293 дугаар тогтоолоор байгуулагдсан. Иймд эдгээр байгууллагууд анхны магадлан итгэмжлэлийн хүсэлтээ гаргаж, үйл явц нь эхлээд байна. Мөн магадлан итгэмжлэлийн хугацаа нь дууссан 7 сургууль дахин магадлан итгэмжлүүлэх хүсэлт ирүүлснээр нийт 9 сургалтын байгууллагад холбогдох процесс явагдаж байна.

Сургалтын үйл ажиллагаа явуулж буй Урлах эрдмийн коллеж нь өмнө нь магадлан итгэмжлэгдэж байгаагүй бөгөөд одоогоор хүсэлт ирүүлээгүй байна. Санхүү, бизнесийн дээд сургуулийн хувьд хоёр дахь удаагийн магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан тул дээд боловсролын байгууллагад мөрдөгдөх хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган, магадлан итгэмжлүүлэх хүсэлтийг дахин ирүүлэх тухай 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 307 тоот албан бичгийг хүргүүлсэн. Гэвч энэ хугацаанд тус сургууль нь Инженерчлэлийн академийн Шинжлэх ухааны коллеж болон өөрчлөгдсөн бөгөөд одоогоор хүсэлт ирүүлээгүй байна.

Түүнчлэн Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Технологийн коллеж болон Шинжлэх ухааны академийн их сургуулиуд нь одоогоор магадлан итгэмжлэлд хамрагдаагүй байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагуудын чанарын баталгаажуулалтын хувьд хуучин шалгуураар магадлан итгэмжлэгдсэн 21 сургалтын байгууллагын шалгуур шаардлагын хэрэгжилтийн дундаж үнэлгээ 1.94 оноо буюу 96.8%-тай үнэлэгдсэн нь шалгуур шаардлагыг бүрэн хангаж, үүнээс эрдэм шинжилгээ судалгааны ажил хамгийн бага, нийгэмд чиглэсэн үйлчилгээ хамгийн өндөр үнэлгээтэй гарсан байна. SHURE үнэлгээний бүтэц загварын шинжилгээгээр дэд үзүүлэлтийн үнэлгээ (88%-98%) гарсан бөгөөд багш ажилтны цалин, урамшуулал хамгийн бага 88% үнэлгээтэй байв.

Харин шинэ шалгуураар магадлан итгэмжлэгдсэн 21 сургалтын байгууллагын шалгуур шаардлагын хэрэгжилтийн дундаж үнэлгээ 3.67 оноо буюу 91.8%-тай үнэлэгдсэн нь шалгуур шаардлагыг хангаж, үүнээс чанарын баталгаажуулалт, эрдэм шинжилгээ инноваци хамгийн бага, засаглал менежмент, нийгэмд чиглэсэн үйлчилгээ хамгийн өндөр үнэлгээтэй гарсан байна. SHURE үнэлгээний бүтэц загварын шинжилгээгээр зарим дэд үзүүлэлтийн үнэлгээ (75%-84%) гарсан байгаа нь тухайн шалгуурыг хэсэгчлэн хангаж цаашид сайжруулах шаардлагатай байгаа нь харагдсан. Тухайлбал засаглал ба менежмент шалгуурт стратегийн хэрэгжилт, үнэлгээ 83%, сургалтын хөтөлбөрийн удирдлагын хувьд суралцахуйн үр дүн 84%, хөтөлбөрийн сайжруулалт 83%, мэдлэг, чадвар, төлөвшлийг үнэлэх журам 83%, цахим сургалтын бодлого, зохицуулалт 83%, хүний нөөцийн хувьд хүний нөөцийн бодлого, хөтөлбөр 83%, цалин, урамшууллын бодлого 83%, материаллаг болон технологийн нөөцийн хувьд лаборатори, тоног төхөөрөмж 84%, номын сангийн баяжилт, хадгалалт 83%, дотуур байр 76%, санхүүгийн эх үүсвэр 76%, суралцахуйг дэмжих үйлчилгээний хувьд ялгаатай хэрэгцээт суралцагчийг дэмжих үйлчилгээ 79%, нийгэмд чиглэсэн үйлчилгээний хувьд нийгмийн аудит 78%, эрдэм шинжилгээ инновацийн хувьд оюуны өмчийн эрх 75%, судалгааны дэд бүтэц, профессорын баг 84%, судалгааны төсөв санхүүжилт 84%, хөрөнгө оруулалт 78%, чанарын баталгаажуулалтын хувьд чанарын дотоод баталгаажуулалт 79%, ил тод байдал 81%, үр дүн 83%, үнэлгээ 84%, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх байдал 76% гэж хамгийн бага үнэлгээтэй байв.



SURE загвараар гарсан шалгуур бүрийн үнэлгээний дундаж /Шинэ шалгуураар/

k	B ₁								B ₂													
	A ₁₁	A ₁₂	A ₁₃	A ₁₄	A ₁₅	A ₁₆	A ₁₇	A ₁₈	A ₂₁	A ₂₂	A ₂₃	A ₂₄	A ₂₅	A ₂₆	A ₂₇	A ₂₈	A ₂₉	A ₂₁₀	A ₂₁₁	A ₂₁₂	A ₂₁₃	
1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	0.67	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67
2	1	0.67	0.67	0.67	1	1	1	1	0.33	1	1	0.67	1	0.67	1	0.67	1	1	1	1	1	1
3	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1
4	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
5	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	0.67	1	0.67	0.67	0.67	0.67	1	1
6	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	0.67	0.67	1	0.67	1	0.67	1	0.67	1	1
7	1	1	0.67	1	1	0.67	1	1	1	1	1	0.67	0.67	0.67	1	1	0.67	1	0.67	1	1	1
8	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
9	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.33
10	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	0.67	1	1	1	1
11	1	1	1	0.67	1	1	1	0.67	1	1	0.67	1	1	1	1	0.83	1	1	1	1	1	1
12	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
13	1	1	1	0.67	0.67	1	1	1	1	1	1	0.33	0.67	1	1	0.33	1	1	1	1	1	1
14	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	0.33	1	1	0.33	1	1	1	1	1	0.33
15	1	1	1	1	0.67	1	1	0.67	0.67	1	0.67	1	1	0.83	1	1	1	0.67	1	1	1	1
16	1	0.67	0.33	0.67	1	1	1	1	0.67	0.67	0.33	0.33	0.67	1	0.33	0.67	0.33	0.67	0.67	0.67	0.67	0.67
17	1	1	1	0.67	1	1	1	0.67	0.67	1	0.67	0.67	0.33	0.33	0.67	0.67	0.67	1	1	1	1	1
18	1	0.67	1	0.67	0.67	1	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.83	0.67	1	0.67	0.67	1	1	1
19	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.83	0.67	1	1	1	1
20	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	0.67	1	1	0.67	1	1	1	1
21	1	0.67	0.67	0.67	0.33	0.67	0.33	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67
Q*(A _{ij})	1	0.94	0.92	0.83	0.92	0.95	0.97	0.92	0.86	0.95	0.89	0.84	0.83	0.87	0.89	0.83	0.87	0.83	0.92	0.94	0.89	0.89
Q _z (B _i)	1								1													

B ₃					B ₄												B ₅						
A ₃₁	A ₃₂	A ₃₃	A ₃₄	A ₃₅	A ₄₁	A ₄₂	A ₄₃	A ₄₄	A ₄₅	A ₄₆	A ₄₇	A ₄₈	A ₄₉	A ₄₁₀	A ₄₁₁	A ₄₁₂	A ₅₁	A ₅₂	A ₅₃	A ₅₄	A ₅₅	A ₅₆	
0.67	0.67	0.67	1	1	1	0.67	1	1	0.67	0.67	1	0.67	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1
1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	0.33	1	0.67	1	0.67	1	1	1	1
1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1
1	1	1	1	1	1	0.67	1	1	0.67	1	1	1	1	1	0	1	1	1	1	1	1	1	1
0.67	0.67	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	0.67	1	1	1	1	1	1	0.67	1	1	0.67	1	1
0.67	0.67	1	0	1	1	0.67	0.67	0.67	1	0.67	0.67	0.67	0.67	1	1	1	1	0.33	1	1	1	1	1
1	1	1	1	1	1	1	1	1	0.93	1	1	1	1	0.33	0.33	1	1	1	1	1	1	1	1
0.67	0.33	1	1	1	0.67	1	1	1	1	0.67	1	0.67	1	1	1	1	1	1	0.33	1	0.67	1	1
1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	0	1	0.67	0.67	1	1	1	1	1	0.67	1
1	1	1	1	0.67	1	0.67	1	0.67	1	0.67	1	0.67	1	1	1	1	1	0.33	1	0.67	1	1	1
1	0.67	1	1	1	1	1	0.67	1	1	1	0.67	1	1	0.67	1	1	0.67	1	1	1	1	1	1
0.67	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.33	1	1	1	1	1	1
1	1	1	0.67	1	1	1	0.67	0.67	0.87	1	0.67	1	0.67	1	0.67	1	1	1	1	1	1	1	1
0.67	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
0.67	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	0.67	1	0.67	1	0.67	1	0.67	1	0.67	0.67	0.67
1	1	1	1	1	1	1	1	0.67	0.87	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1
1	1	0.67	0.67	1	1	1	0.67	0.67	0.87	1	1	0.67	0.67	1	0	1	1	0.67	1	1	1	1	1
0.67	0.67	1	1	0.67	1	0.67	1	0.67	1	0.67	1	0.33	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
0.33	0.33	0.67	0.67	0.67	0.33	0.67	0.67	0.67	0.67	1	0.67	0.67	0.67	0	0.67	0.33	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67
0.83	0.83	0.95	0.9	0.95	0.95	0.84	0.92	0.83	0.93	0.9	0.94	0.76	0.92	0.87	0.76	0.92	0.95	0.79	0.97	0.9	0.92	0.97	0.97
0.98					1												0.98						

B6						B7									B8									Q _{г,к} (C)
A61	A62	A63	A64	A65	A66	A71	A72	A73	A74	A75	A76	A77	A78	A79	A81	A82	A83	A84	A85	A86	A87	A88		
1	1	0.67	1	1	0.67	1	1	0.67	0.67	0.67	1	1	1	0.67	1	1	1	1	0.67	1	1	0.67	1	
1	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	0.67	0.67	1	0.67	1	1	0.67	1	1	1	1	
1	1	1	1	1	0.67	1	1	1	0.67	0.33	1	1	1	1	1	1	1	1	0.67	0.67	1	1	1	
1	1	0.67	1	1	1	1	0.67	0.67	1	0.67	0.67	1	0.67	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	
1	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	0.67	1	1	1	1	1	0.33	0.67	0.67	1	1	1	
1	1	1	1	1	0.33	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.33	0.67	0.67	0.67	1	1	1	1	
1	1	0.67	0.67	1	0.67	1	0.67	1	0.67	0	0.67	0.67	0.67	0.67	0.67	0	1	0.67	0.67	0	0.67	0.67	1	
1	1	1	1	1	0.67	1	1	0.67	1	0.67	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	0.67	1	
1	0.67	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	
1	1	1	0.67	1	1	1	1	1	1	0.83	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	0.67	1	0.67	
1	1	1	1	1	0.67	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	
1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	
1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	0.67	0.67	1	1	0.67	1	1	1	1	1	
1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	0.67	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	0	1	
1	1	1	1	0.67	1	1	1	1	0.33	0.5	0.33	1	0.33	0.33	1	1	0.67	0.67	1	1	1	1	1	
1	0.67	1	0.67	1	0.67	1	0.67	1	0.67	0.67	0.67	1	1	0.67	1	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.33	
1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	0.33	0	1	0.67	1	1	1	1	1	1	1	
1	1	1	0.67	1	1	1	0.67	1	1	0.67	1	1	1	0.33	1	0.67	1	0.67	0.67	0.67	1	1	0.67	
1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	0.67	0.67	0.67	1	1	1	0.67	1	1	0.67	0.67	1	
0.67	1	1	1	0.67	0.67	1	1	1	1	0.67	0.67	1	1	1	0.67	1	1	0.67	1	1	0.67	0.67	1	
0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.67	0.33	0.33	0.67	0.67	0.33	0.33	0.33	0.67	0.67	0.33	0.67	0.33	0.67	0.33	0.33	0.33	0.71	
0.97	0.95	0.94	0.9	0.95	0.78	0.97	0.9	0.9	0.87	0.75	0.84	0.92	0.84	0.78	0.94	0.79	0.94	0.81	0.83	0.84	0.9	0.76	Q _г (C) = 0.986	
0.98						0.98									0.98									

Чанарын шинжилгээний үр дүнгээр сургуулиуд дээр нийтлэг анхааруулах цаашид сайжруулах шаардлагатай хүчин зүйлсүүд байна. Үүнд:

Шалгуур 1. Засаглал ба менежмент:

Байгууллагын засаглал, стратеги төлөвлөлт, дотоод хяналт, оролцогч талуудын оролцоог боловсронгуй болгох шаардлага давамгайлж байна. Стратеги төлөвлөгөө, алсын хараа, эрхэм зорилгыг улсын болон бүс нутгийн хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээтэй уялдуулах, хэрэгжилтийг хэмжигдэхүйц KPI-тайгаар үнэлэх хэрэгцээ өндөр байна.

Мөн дүрэм, журам, эрх зүйн баримт бичгийн уялдаа холбоо, шинэчлэл, цахимжуулалт, дотоод аудитын тогтолцоог сайжруулах шаардлага тодорхой харагдаж байна. Оролцогч талуудын (оюутан, багш, төгсөгч, ажил олгогч) оролцоог стратеги, бодлого боловсруулах бүхий л шатанд тогтмолжуулах шаардлагатай байна.

Гадаад, дотоод хамтын ажиллагаа, судалгаа шинжилгээ, чанарын удирдлагын тогтолцоог олон улсын жишигт хүргэх, ил тод тайлагнах, хяналт-шинжилгээ үнэлгээг тогтмолжуулах хэрэгцээ нийтлэг илэрч байна.

Шалгуур 2. Сургалтын хөтөлбөрийн удирдлага:

Сургалтын хөтөлбөрийг үр дүнд суурилсан боловсролын үзэл баримтлалд бүрэн нийцүүлэн шинэчлэх шаардлага зонхилж байна. Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (PLO, CLO), үнэлгээ, багшлах арга зүй, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээний уялдаа холбоог сайжруулах хэрэгцээ өндөр байна.

Хөтөлбөр боловсруулах, үнэлэх, шинэчлэх үйл явцад ажил олгогч, төгсөгч, мэргэжлийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөн А/147 тушаалын хэрэгжилтийг хангаж, олон улсын жишиг, магадлан итгэмжлэлийн шаардлагад нийцүүлэх асуудал онцгой анхаарал татаж байна.

Суралцагч төвтэй сургалт, зөөлөн ур чадвар, англи хэл, дижитал ур чадвар, судалгаанд суурилсан сургалтын арга зүйг хөтөлбөрт түлхүү тусгах, хөтөлбөрийн хэрэгжилтэд тогтмол дүн шинжилгээ хийдэг тогтолцоо шаардлагатай байна.

Шалгуур 3. Хүний нөөц:

Хүний нөөцийн бодлого нь багш, ажилтны хөгжил, тогтвортой байдал, урамшуулал, карьер хөгжлийг илүү системтэй төлөвлөх шаардлагатай байна. Эрдмийн зэрэг цолтой багшийн тоог нэмэгдүүлэх, залуу багшийг хөгжүүлэх, багшийн ачааллыг оновчтой тогтоох асуудал нийтлэг дурдагдсан байна.

Цалин, урамшууллын бодлогыг судалгаанд суурилан шинэчлэх, гүйцэтгэл, эрдэм шинжилгээний бүтээмжтэй уялдуулах шаардлага өндөр байна. Мөн багш, ажилтны хөгжлийн хөтөлбөр, аттестатчилал, менторшип, дасан зохицуулах тогтолцоог боловсронгуй болгох хэрэгтэй байна.

Хүний нөөцийн мэдээллийн системийг хөгжүүлэх, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалтыг сайжруулах, гадаад хамтын ажиллагаа, багш солилцоо, судалгааны хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байна.

Шалгуур 4. Материаллаг болон технологийн нөөц:

Сургалтын орчин, лаборатори, техник тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн дэд бүтцийг шинэчлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээ өндөр байна. Лабораторийн аюулгүй байдал, баталгаажуулалт, магадлан итгэмжлэл, шинэ тоног төхөөрөмжөөр хангах шаардлага түлхүү тавигдсан байна.

Номын сан, цахим сан, программ хангамж, ERP болон удирдлагын мэдээллийн системийг хөгжүүлэх, цахим контент, онлайн мэдээллийн сангийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Мөн сургалтын байр, дотуур байр, интернет орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах, санхүүгийн эх үүсвэрийг төрөлжүүлэх, судалгаа болон төсөл хөтөлбөрөөс орлого нэмэгдүүлэх асуудал чухлаар тавигдсан байна

Шалгуур 5. Суралцахуйг дэмжих үйлчилгээ:

Оюутанд чиглэсэн үйлчилгээ, дэмжлэг, сэтгэл зүй, хөдөлмөр эрхлэлт, тэтгэлэг, хөгжлийн үйл ажиллагааг илүү хүртээмжтэй, системтэй болгох шаардлага харагдаж байна. Оюутны санал хүсэлт, сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн шийдвэр гаргах, эргэн мэдээлэх тогтолцоог сайжруулах хэрэгтэй байна.

Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад зориулсан орчин, үйлчилгээ, тусгай тоног төхөөрөмж, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө, эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг сайжруулах шаардлага нийтлэг байна.

Оюутны клуб, сайн дурын үйл ажиллагаа, хөдөлмөр эрхлэлт, гадаад солилцоо, тэтгэлгийн бодлого, дижитал мэдээллийн хүртээмжийг өргөжүүлэх чиглэлд тогтвортой бодлого хэрэгтэй байна.

Шалгуур 6. Нийгэмд чиглэсэн үйлчилгээ:

Нийгмийн хариуцлага, түншлэл, насан туршийн боловсролын үйлчилгээ, олон нийтэд чиглэсэн сургалт, төслийн үйл ажиллагааг стратегийн түвшинд удирдах шаардлага тодорхой байна.

Нийгмийн үйлчилгээний хэрэгжилтэд мониторинг, үнэлгээ, нийгмийн аудит хийх, оролцогч талуудын санал оролцоог тогтмол тусгах тогтолцоо сул байгааг зөвлөмжүүд харуулж байна.

Мөн ажил олгогч, төгсөгч, байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, практик сургалт, хөдөлмөр эрхлэлт, судалгаа шинжилгээ, олон нийтэд зориулсан сургалтыг тогтмолжуулах, үр дүнг ил тод тайлагнах шаардлагатай байна.

Шалгуур 7. Эрдэм шинжилгээ, инновац:

Эрдэм шинжилгээ, инновацийн чиглэлээр сургалт–судалгаа–үйлдвэрлэлийн уялдаа холбоог бэхжүүлэх, судалгаанд суурилсан их сургуулийн хөгжлийн загварыг төлөвшүүлэх шаардлага давамгайлж байна. Судалгааны бодлого, тэргүүлэх чиглэлийг байгууллагын алсын хараа, үндэсний хөгжил, нийгмийн хэрэгцээтэй уялдуулан тодорхойлох, хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтээр үнэлэх тогтолцоог боловсронгуй болгох хэрэгцээ тодорхой байна.

Мөн эрдэм шинжилгээ, инновацийн удирдлагын тогтолцоог бэхжүүлж судалгааны стратегийн зорилтот үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, нөөцийн төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог тогтмолжуулах шаардлага харагдаж байна.

Судалгааны чанарын баталгаажуулалт, технологи дамжуулалт, шинэ мэдлэг бүтээх тогтолцоог хөгжүүлэх, эрдэм шинжилгээний үр дүнг сургалт болон үйлдвэрлэлд нэвтрүүлэх асуудал онцгой ач холбогдолтой байна. Судалгааны ёс зүй, оюуны өмчийн хамгаалалт, бүтээлийн хуулбарлалттай тэмцэх бодлого, зохицуулалт, зориулалтын программ ашиглалтыг хөгжүүлэх шаардлага мөн тодорхой тусгагдсан байна.

Түүнчлэн профессорын баг, судалгааны дэд бүтэц, лаборатори, судалгааны оролцоог дэмжих механизм, багш, ажилтан, суралцагчдын хамтын оролцоо, олон эх үүсвэртэй санхүүжилт зэргийг системтэй хөгжүүлэх хэрэгцээ өндөр байна.

Шалгуур 8. Чанарын баталгаажуулалт :

Чанарын баталгаажуулалтын чиглэлээр байгууллагын стратеги, сургалт, судалгаа, удирдлага, оролцогч талуудын хэрэгцээтэй уялдсан тасралтгүй сайжруулалтын тогтолцоог хөгжүүлэх шаардлага зонхилж байна. Чанарын удирдлагын бодлого, бүтэц, журам, гарын авлага, нөөц, санхүүжилтийг бүрдүүлж, байгууллагын хэмжээнд нэгдсэн чанарын удирдлагын тогтолцоог бүрэн хэрэгжүүлэх шаардлага тодорхой байна.

Мөн чанарын дотоод баталгаажуулалт, өөрийн үнэлгээ, хяналт-шинжилгээ, гүйцэтгэлийн үнэлгээ, өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, оролцогч талуудын саналд тулгуурласан сайжруулалт зэрэг үйл ажиллагааг тогтмолжуулах хэрэгцээ өндөр байна.

Чанарын соёлыг байгууллагын бүх түвшинд төлөвшүүлэх, багш, ажилтан, суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх, ил тод байдал, хариуцлагыг бэхжүүлэх асуудал чухлаар тавигдаж байна.

Түүнчлэн үндэсний болон олон улсын магадлан итгэмжлэл, чанарын үнэлгээний шаардлагад нийцэх, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөхүйц чанарын тогтолцоог хөгжүүлэх чиг хандлага тодорхой ажиглагдаж байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын дээд боловсролын тогтолцоо нь чанар, хөдөлмөрийн зах зээлтэй уялдаа, судалгаа-инновац, санхүүжилт болон олон улсын өрсөлдөх чадварын хувьд шинэчлэл шаардсан үе шатанд байна.

Дээд боловсролын шинэчлэлийн бодлогын зорилтуудтай уялдуулан чанарын баталгаажуулалтын чиглэлээр засаглал, дижитал шилжилт, санхүүжилт, судалгаа-инновац болон тогтвортой хөгжлийн чиглэлээр дараах саналуудыг нэгтгэн гаргалаа. Үүнд:

1. Боловсролын Яаманд:

Бодлого, эрх зүйн орчны хүрээнд:

- Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын бодлогыг SDG-4 болон тогтвортой хөгжлийн зорилготой уялдуулан шинэчлэх;
- Судалгаанд суурилсан их сургуулийн хөгжлийн бодлогыг үе шаттай хэрэгжүүлэх;
- Дижитал шилжилт, AI, өгөгдөлд суурилсан боловсролын удирдлагын нэгдсэн бодлого боловсруулах;
- Их, дээд сургуулийн бие даасан байдал болон хариуцлагын тэнцвэрийг боловсронгуй болгох.

Санхүүжилт, дэмжлэгийн хүрээнд:

- Судалгаа, инновацийн санхүүжилтийн тогтолцоог өргөжүүлэх;
- Гүйцэтгэл, чанар, хөдөлмөр эрхлэлтэд суурилсан санхүүжилтийн загвар нэвтрүүлэх;
- Орон нутгийн болон жижиг сургуулиудад чанарын баталгаажуулалтын чадавх бэхжүүлэх дэмжлэг үзүүлэх;
- Ногоон кампус, хүртээмжтэй боловсрол, дижитал дэд бүтцийг дэмжих тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд:

- Үндэсний хэмжээний боловсролын чанарын өгөгдлийн нэгдсэн систем хөгжүүлэх;
- Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт, ур чадварын мониторингийг тогтмол хийх;
- Магадлан итгэмжлэлийн дараах хэрэгжилтийн мониторингийн тогтолцоог бэхжүүлэх.

2. Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлд:

Шалгуур, аргачлалын хүрээнд:

- Дээд боловсролын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуурт SDG-4 тогтвортой хөгжил, ногоон хөгжил, хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг тусгасан шалгуур нэмэх;

- Судалгаа, инноваци, олон улсын хамтын ажиллагааны үнэлгээний жинг нэмэгдүүлэх;
- Чанарын соёл, тасралтгүй сайжруулалтын үнэлгээний аргачлалыг илүү бодитой болгох.

Үнэлгээний үйл ажиллагааны хүрээнд:

- Шинжээчдийн мэргэшүүлэх, давтан сургалтыг тогтмолжуулах;
- Үнэлгээний ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх;
- Цахим магадлан итгэмжлэл, өгөгдөлд суурилсан үнэлгээний платформ хөгжүүлэх;
- Олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Судалгаа, хөгжлийн хүрээнд:

- Магадлан итгэмжлэлийн үр нөлөөний үндэсний судалгаа хийх;
- Дээд боловсролын чанарын хөгжлийн индекс боловсруулах;
- Сайн туршлагын сан, жишиг кейсийн мэдээллийн сан бий болгох.

3. Сургалтын байгууллагад:

Засаглал, менежментийн хүрээнд:

- Стратеги төлөвлөгөөг хөдөлмөрийн зах зээл, тогтвортой хөгжил, инновацын чиг хандлагатай уялдуулах;
- Өгөгдөлд суурилсан удирдлага, чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог хөгжүүлэх;
- Оролцогч талуудын оролцоог бодлого боловсруулах түвшинд тогтмолжуулах.

Сургалт, хүний нөөцийн хүрээнд:

- Суралцахуйн үр дүнд суурилсан хөтөлбөрийн шинэчлэлийг тогтмол хийх;
- Багшийн хөгжлийн бодлого, судалгааны бүтээмжийн үнэлгээг сайжруулах;
- Дижитал ур чадвар, AI, зөөлөн ур чадварын сургалтыг өргөжүүлэх;
- Оюутан төвтэй сургалтын арга зүйг тогтвортой хэрэгжүүлэх.

Судалгаа, инновацын хүрээнд:

- Судалгааны тэргүүлэх чиглэлээ үндэсний болон бүс нутгийн хөгжлийн хэрэгцээтэй уялдуулах;
- Инноваци, стартап, технологи дамжуулалтын дэмжих орчныг бүрдүүлэх;
- Олон улсын хамтарсан судалгаа, индексжүүлсэн бүтээлийг нэмэгдүүлэх.

Нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн хүрээнд:

- Ногоон кампус, эрчим хүчний хэмнэлт, цаасгүй удирдлагын бодлого хэрэгжүүлэх;
- Хүртээмжтэй боловсрол, тэгш оролцоог хангах;
- Орон нутаг, нийгмийн хэрэгцээнд чиглэсэн үйлчилгээ, сургалт хэрэгжүүлэх.

Хавсралт 02.

2. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтад хийсэн шинжилгээний үр дүн

Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг 2004 оноос хийж эхэлсэн.

Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг 2004 оноос хийж эхэлсэн. Монгол Улсын хэмжээнд 2025-2026 оны хичээлийн жилд сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 68 дээд боловсролын сургалтын байгууллагад нийт 2274 хөтөлбөр хэрэгжиж байна.

2025-2026 оны 2-р улирлын байдлаар нийт 978 хөтөлбөр БМИҮЗ-өөр магадлан итгэмжлэгдсэнээс 526 хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хүчинтэй байгаа нь нийт хөтөлбөрийн 23.9 хувийг эзэлж байна. Үүнээс бакалаврын 400, магистрын 92, докторын 14, дэд бакалаврын 20 хөтөлбөр байгаа бөгөөд магадлан итгэмжлэгдсэн нийт хөтөлбөрийн 71.1% нь төрийн өмчийн, 28.9% төрийн бус өмчийн ДБСБ-ын хөтөлбөр байна.

Мөн энэ хугацаанд 16 их, дээд сургууль 110 гаруй хөтөлбөрөө олон улсад магадлан итгэмжлүүлжээ.

Магадлан итгэмжлэгдсэн нийт хөтөлбөрийн мэдээлэл:

Он	МИ-сэн хөтөлбөрийн тоо	Төрийн өмчийн сургууль	Төрийн бус өмчийн сургууль	Бакалавр	Магистр	Доктор	Дэд бакалавр
2004	3	3		2	1		
2005	4	1	3	4			
2006	7	6	1	7			
2008	6	5	1	4	2		
2009	16	15	1	16			
2010	10	10		8	2		
2011	41	37	4	38	3		
2012	31	17	14	25	6		
2013	37	35	2	35	2		
2014	33	23	10	29	3	1	
2015	29	13	16	28	1		
2017	1	1		1			
2018	45	41	4	44	1		
2019	47	34	13	43	3	1	
2020	45	35	10	41	3	1	
2021	89	60	29	70	16	2	1
2022	84	55	29	70	9	2	3
2023	56	42	14	33	10	7	6
2024	244	159	85	185	47	4	8
2025	116	76	40	98	15		3
2026	34	26	8	27	5		2
Нийт	978	694	284	808	129	18	23
		978		978			

А/146 дугаар тушаалаар батлагдсан Дээд боловсролын байгууллагад мөрдөх мэргэжлийн чиглэл /хөтөлбөрийн нэр/ индексийн жагсаалтад Монгол Улсын хэмжээнд 10

ерөнхий чиглэлээр бакалаврын 277 индексээр 1230 хөтөлбөр, магистрын 313 индексээр 731 хөтөлбөр, докторын 130 индексээр 246 хөтөлбөр, дэд бакалаврын 22 индексээр 67 хөтөлбөр хэрэгжиж чанарын баталгаажуулалтыг мэргэжлийн чиглэлээр нь нарийвчлан авч үзвэл дараах үзүүлэлттэй байна.

Мэргэжлийн чиглэл	Хөтөлбөрийн тоо	Магадлан итгэмжлэгдсэн	МИ-сэн хувь
01-Боловсрол	270	108	40.0%
02-Урлаг хүмүүнлэг	285	49	17.2%
03-НШУ, мэдээлэл сэтгүүл зүй	163	25	15.3%
041-Бизнес, удирдлага	337	57	16.9%
042-Эрх зүй	50	9	18.0%
05-БШУ, Мат Стат	149	28	18.8%
06-МХХТ	112	35	31.3%
07-Инженерчлэл ҮББ	499	102	20.4%
08-ХАА, Ой,ЗАА, МЭЗ	72	15	20.8%
091-Эрүүл мэнд	178	60	33.7%
092-Нийгмийн хамгаалал	31	10	32.3%
10-Үйлчилгээ	128	28	21.9%
Бүгд	2274	526	23.9%

Боловсролын багц хууль батлагдсантай холбоотой, эрх зүйн баримт бичгүүд, шалгуур шаардлага, үнэлгээг багцаар нь өөрчлөх шаардлагатай болсон. Боловсролын ерөнхий хуулийн 12.5-д “Дээд боловсролын сургалтын байгууллага магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр багшийг бэлтгэнэ”, Дээд боловсролын тухай хуулийн 12.11-д “Анагаах ухааны мэргэжлийн чиглэлийн сургалтын хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ”, 12.6-д “тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг 5 жил тутам магадлан итгэмжилнэ” гэж тус тус заасан.

Эрэлттэй, тэргүүлэх, багш, анагаахын чиглэлийн нийт 1123 хөтөлбөрөөс 326 хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн хугацаа хүчинтэй байгаа нь нийт хөтөлбөрийн 29%-ийг эзэлж байна.

Мэргэжлийн чиглэл	Хөтөлбөрийн тоо	Магадлан итгэмжлэгдсэн	МИ-сэн хувь
01-Боловсрол	270	108	40.0%
02-Урлаг хүмүүнлэг	17	7	41.2%
03-НШУ, мэдээлэл сэтгүүл зүй	34	7	20.6%
041-Бизнес, удирдлага	5	1	20.0%
05-БШУ, Мат Стат	68	16	23.5%
06-МХХТ	85	23	27.1%
07-Инженерчлэл ҮББ	309	74	23.9%
08-ХАА, Ой,ЗАА, МЭЗ	55	13	23.6%
091-Эрүүл мэнд	178	56	31.5%
092-Нийгмийн хамгаалал	31	10	32.3%
10-Үйлчилгээ	71	11	15.5%
Бүгд	1123	326	29.0%

Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагыг анх 2004 онд баталж, 2010, 2015, 2018, 2020, 2024 онуудад олон улсын чиг хандлага, үнэлгээнд баримтлах

зарчмууд болон холбогдох хууль тогтоомжийг судалж, үндэсний онцлогт нийцүүлэн шинэчлэн баталсан.

Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын хувьд 2024 онд хуучин шалгуураар магадлан итгэмжлэгдсэн 108 бакалаврын хөтөлбөрийн шалгуур шаардлагын хэрэгжилтийн дундаж үнэлгээ 1.92 оноо буюу 95.8%-тай үнэлэгдсэн нь шалгуур шаардлагыг бүрэн хангаж, үүнээс багшийн үйл ажиллагаа, чанарын үнэлгээ баталгаажуулалт хамгийн бага, суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа, хөтөлбөрийн төлөвлөлт хамгийн өндөр үнэлгээтэй гарсан байна. SHURE үнэлгээний бүтэц загварын шинжилгээгээр дэд үзүүлэлтийн үнэлгээ (88%-98%) гарсан бөгөөд эрдэм шинжилгээ, судалгаа дэд шалгуур хамгийн бага 88% үнэлгээтэй байв.



k	B ₁			B ₂			B ₃			B ₄				
	A ₁₁	A ₁₂	A ₁₃	A ₂₁	A ₂₂	A ₂₃	A ₃₁	A ₃₂	A ₃₃	A ₄₁	A ₄₂	A ₄₃	A ₄₄	A ₄₅
1	1	0.95	0.9	0.95	1	0.9	1	0.95	0.95	0.95	0.9	0.95	1	1
2	1	0.95	1	0.9	0.9	0.9	1	0.95	0.8	0.9	0.9	0.9	0.95	1
3	1	1	1	0.85	1	1	1	1	1	0.85	1	1	1	1
4	1	1	0.95	0.95	1	0.95	0.95	1	1	1	1	0.95	0.95	0.95
5	1	1	1	0.95	1	1	1	0.95	0.95	1	1	1	1	1
6	0.95	1	1	1	0.95	1	0.9	0.95	1	1	1	1	0.95	1
7	1	1	0.85	0.9	1	1	0.95	1	1	0.95	1	1	1	1
8	1	0.85	1	1	1	0.85	1	1	1	1	0.85	1	1	0.85
Q*(A _{ij})	0.99	0.97	0.96	0.94	0.98	0.95	0.98	0.98	0.96	0.96	0.96	0.98	0.98	0.98
Q*(B _i)	1			0.99			1			1				

B_5					B_6				B_7			$Q_{e,k}^*(C)$
A_{51}	A_{52}	A_{53}	A_{54}	A_{55}	A_{61}	A_{62}	A_{63}	A_{64}	A_{71}	A_{72}	A_{73}	
0.95	0.95	1	0.95	1	0.8	1	0.75	1	0.95	0.95	1	1
0.95	0.95	0.9	0.9	0.9	0.95	0.8	0.75	0.9	0.8	0.9	0.95	0.94
1	1	1	1	1	1	0.85	1	1	1	1	0.85	1
1	0.95	0.95	1	1	1	0.95	1	1	0.9	0.95	0.9	0.99
1	1	1	1	1	0.95	1	1	1	1	1	1	1
1	1	1	1	1	1	1	0.9	0.95	1	1	1	1
1	1	1	1	1	0.9	1	0.95	1	1	1	1	1
1	1	1	1	1	1	1	0.65	1	0.85	1	0.85	1
0.99	0.98	0.98	0.98	0.99	0.95	0.95	0.88	0.98	0.94	0.98	0.94	$Q_e^*(C) = 0.9912$
0.99					0.98				0.98			

Шалгуур шаардлагын дундаж үнэлгээг мэргэжлийн чиглэл бүрээр нь нарийвчлан авч үзвэл дараах дундаж үнэлгээтэй байв.

Шалгуур үзүүлэлтүүд	01 Боловсрол	041 Бизнес, удирдлага	042 Эрх зүй	05 Мат Стат	06 МХХТ	07 Инженерчлэл ҮББ	091-Эрүүл мэнд	092 Нийгмийн хамгаалал	Нэгдсэн	Хувь
Хөтөлбөрийн төлөвлөлт	1.91	2.00	2.00	1.97	2.00	1.95	1.90	1.9	1.95	97.6%
Сургалтын үйл ажиллагаа	1.91	1.71	1.89	1.93	1.98	1.95	1.92	1.9	1.90	94.9%
Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	1.94	1.81	2.00	1.97	1.96	1.90	1.94	2.0	1.94	97.0%
Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт	1.93	1.80	1.93	1.94	2.00	1.96	1.97	1.9	1.93	96.3%
Суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа	1.95	1.77	2.00	1.96	2.00	1.99	1.99	2.0	1.96	97.8%
Багшийн үйл ажиллагаа	1.80	1.64	1.92	1.98	1.98	1.91	1.93	1.8	1.87	93.7%
Чанарын үнэлгээ баталгаажуулалт	1.80	1.71	1.89	1.83	2.00	1.99	1.98	1.8	1.87	93.6%
Дундаж оноо	1.89	1.78	1.95	1.94	1.99	1.95	1.95	1.89	1.92	95.8%
Дундаж хувь	94.4%	88.9%	97.3%	97.0%	99.4%	97.5%	97.5%	94.7%	95.8%	

Чанарын шинжилгээний үр дүнгээр сургуулиуд дээр нийтлэг анхааруулах цаашид сайжруулах шаардлагатай хүчин зүйлсүүд байна. Үүнд:

Шинжээчдийн багаас өгсөн нийт 108 хөтөлбөрт өгсөн 2400 зөвлөмж, 182 шаардлагад (нийт 2582) чанарын анализ (агуулгын шинжилгээ) хийлээ.

Өгсөн зөвлөмж шаардлагууд	Зөвлөмж	Шаардлага	Нийт	Хувийн жин	Дундаж
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	333	23	356	13.8%	1.95
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	316	25	341	13.2%	1.90
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	376	27	403	15.6%	1.94
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	409	27	436	16.9%	1.93
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	339	12	351	13.6%	1.96
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	398	47	445	17.2%	1.87
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	229	21	250	9.7%	1.87
Нийт	2400	182	2582	100.0%	1.92

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, үндэсний болон олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулах шаардлага нийтлэг ажиглагдаж байна. Мөн зорилго, зорилтын хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлт, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох, оролцогч талуудын саналд үндэслэн тогтмол шинэчлэх хэрэгцээ өндөр байна.

Хөтөлбөрийн агуулга болон суралцахуйн үр дүнг олон улсын жишиг, мэргэжлийн стандарттай нийцүүлэх шаардлага давамгайлж байна. Практик ур чадвар, судалгаанд суурилсан агуулгыг нэмэгдүүлэх, төгсөгчдийн эзэмших чадварыг тодорхой, хэмжигдэхүйц байдлаар томъёолох хэрэгцээ нийтлэг илэрч байна.

Хөтөлбөрийн шинэчлэлийг нотолгоо, судалгаа, эрэлт хэрэгцээнд тулгуурлан хэрэгжүүлэх шаардлага ажиглагдаж байна. Төгсөгч, ажил олгогч, мэргэжлийн байгууллагын оролцоог тогтмолжуулах, хөтөлбөрийн сайжруулалтыг тасралтгүй хэрэгжүүлэх хэрэгцээ өндөр байна.

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын арга зүйг суралцагч төвтэй, орчин үеийн хэлбэрт шилжүүлэх шаардлага нийтлэг байна. Идэвхтэй сургалтын арга, кейс, төсөл, судалгаанд суурилсан хичээлийн зохион байгуулалтыг нэмэгдүүлэх хэрэгцээ ажиглагдаж байна.

Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг бодитой үнэлэх үнэлгээний шалгуур, аргачлалыг боловсронгуй болгох шаардлага давамгайлж байна. Үнэлгээний ил тод байдал, эргэх холбоо, суралцахуйн үр дүнтэй уялдсан үнэлгээг тогтмолжуулах хэрэгцээ өндөр байна.

Дадлага, практик сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлага нийтлэг ажиглагдаж байна. Суралцагчдыг бодит ажлын орчинд суралцах боломжийг нэмэгдүүлэх хэрэгцээ өндөр байна.

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин

Сургалтын орчны тохижилт, хүртээмж, аюулгүй байдлыг сайжруулах шаардлага нийтлэг илэрч байна. Танхим, лаборатори, дадлагын орчныг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх хэрэгцээ өндөр байна.

Ном, сурах бичиг, цахим мэдээллийн сангийн хүртээмжийг нэмэгдүүлэх, олон улсын эх сурвалж ашиглалтыг өргөжүүлэх шаардлага ажиглагдаж байна. Суралцагч, багшийн мэдээллийн хэрэгцээг хангахуйц нөөц бүрдүүлэх хэрэгцээ нийтлэг байна.

Цахим сургалтын платформ, мэдээллийн системийн ашиглалт, чанарыг сайжруулах шаардлага давамгайлж байна. Онлайн сургалтын агуулга, үнэлгээ, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох хэрэгцээ өндөр байна.

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн төлөвлөгөө, тайлангийн хэрэгжилтэд тогтмол үнэлгээ хийх, үр дүнд суурилсан удирдлагын тогтолцоог хөгжүүлэх шаардлага нийтлэг байна. Хэрэгжилтийн тайлагнал, хяналтыг сайжруулах хэрэгцээ ажиглагдаж байна.

Оролцогч талуудын санал, оролцоог бодлого боловсруулах, хөтөлбөр шинэчлэх бүхий л шатанд тогтмолжуулах шаардлага давамгайлж байна. Төгсөгч, ажил олгогч, суралцагчийн эргэх холбоог тогтмол ашиглах хэрэгцээ өндөр байна.

Гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх, оюутан, багшийн солилцоо, хамтарсан судалгааны ажлыг нэмэгдүүлэх шаардлага нийтлэг илэрч байна. Олон улсын түншлэл, хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх хэрэгцээ ажиглагдаж байна.

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Суралцагчийн хөгжил, оролцоо, карьер төлөвлөлтийг дэмжих үйлчилгээ, зөвлөгөөний тогтолцоог боловсронгуй болгох шаардлага нийтлэг байна. Оюутны хэрэгцээнд тулгуурласан дэмжлэгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээ өндөр байна.

Суралцагчдыг эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөр, сайн дурын болон олон нийтийн үйл ажиллагаанд татан оролцуулах шаардлага ажиглагдаж байна. Судалгааны ажлын оролцоо, урамшууллын тогтолцоог сайжруулах хэрэгцээ нийтлэг байна.

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн мэргэжлийн хөгжил, судалгааны чадавх, заах арга зүйн шинэчлэлийг тогтмол дэмжих шаардлага давамгайлж байна. Сургалт, семинар, туршлага солилцооны боломжийг нэмэгдүүлэх хэрэгцээ өндөр байна.

Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийг нэмэгдүүлэх, олон улсын сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх үйл ажиллагааг дэмжих шаардлага нийтлэг ажиглагдаж байна. Судалгааны төсөл, хамтын ажиллагааг өргөжүүлэх хэрэгцээ өндөр байна.

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог боловсронгуй болгож, тогтмол хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шаардлага нийтлэг илэрч байна. Чанарын мэдээллийг шийдвэр гаргалтад ашиглах хэрэгцээ өндөр байна.

Суралцагч, төгсөгч, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, үр дүнд тулгуурлан сайжруулалт хийх шаардлага давамгайлж байна. Эргэх холбооны тогтолцоог илүү үр дүнтэй хэрэгжүүлэх хэрэгцээ нийтлэг байна.

Хөтөлбөрийн хэрэгжилт, чанарын үнэлгээ, тайлагналын мэдээллийг ил тод, нээлттэй хүргэх шаардлага ажиглагдаж байна. Тайлагналын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах хэрэгцээ өндөр байна.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

Боловсролын Яаманд:

- Дээд боловсролын бодлого, хөгжлийн чиглэлийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, бүсчилсэн хөгжил, олон улсын чиг хандлагатай илүү уялдуулан боловсруулах; хөтөлбөрийн шинэчлэлд дэмжлэг үзүүлэх эрх зүй, бодлогын орчныг боловсронгуй болгох;
- Сургалтын хөтөлбөрийн чанарын үнэлгээ, гүйцэтгэлийг үр дүнд суурилсан шалгуур үзүүлэлтээр үнэлэх нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх, KPI-д суурилсан хяналт-шинжилгээний механизмыг нэвтрүүлэх;
- Багшийн хөгжил, судалгаа шинжилгээ, инноваци, олон улсын хамтын ажиллагааг дэмжих санхүүжилт, тэтгэлэг, төсөл хөтөлбөрийг нэмэгдүүлэх;
- Цахим сургалт, мэдээллийн нэгдсэн сан, боловсролын дата удирдлагын тогтолцоог улсын хэмжээнд хөгжүүлэх, сургалтын байгууллагуудын цахим шилжилтийг дэмжих;
- Төгсөгчийн хөдөлмөр эрхлэлт, ажил олгогчийн сэтгэл ханамж, ур чадварын хэрэгцээний үндэсний хэмжээний судалгааг тогтмолжуулж, бодлого боловсруулахад ашиглах;
- Орон нутаг болон салбарын онцлогт нийцсэн мэргэжлийн хөтөлбөрүүдийг дэмжих, чанартай боловсон хүчин бэлтгэх бодлогын уялдааг сайжруулах.

Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлд:

- Магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагыг олон улсын чанарын баталгаажуулалтын жишигтэй тогтмол уялдуулан шинэчлэх;
- Хөтөлбөрийн үнэлгээнд суралцахуйн үр дүн, төгсөгчийн хөдөлмөр эрхлэлт, ажил олгогчийн үнэлгээ, оролцогч талуудын эргэх холбоонд суурилсан үнэлгээний жинг нэмэгдүүлэх;
- Магадлан итгэмжлэлийн дараах зөвлөмж, шаардлагын хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ, зөвлөн дэмжих тогтолцоог боловсронгуй болгох;
- Үнэлгээний тайлан, зөвлөмж боловсруулах аргачлал, нотолгоонд суурилсан үнэлгээний чанарыг жигд сайжруулах, шинжээчдийн чадавхыг тогтмол хөгжүүлэх;
- Дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр сургалтын байгууллагуудад зөвлөн туслах, сайн туршлага түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулах;
- Магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаанд цахим үнэлгээ, мэдээллийн удирдлагын системийг өргөн ашиглаж, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх.

Сургалтын байгууллага, хөтөлбөр хэрэгжүүлэгчдэд:

- Хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүнг хөдөлмөрийн зах зээл, мэргэжлийн стандарт, олон улсын хөгжлийн чиг хандлагатай уялдуулан тогтмол шинэчлэх;
- Сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний тогтолцоог суралцагч төвтэй, практик болон судалгаанд суурилсан хэлбэрээр хөгжүүлэх;
- Дадлага, үйлдвэрлэл, ажил олгогчтой хамтарсан сургалтын орчныг өргөжүүлж, төгсөгчдийн ажил эрхлэлтийн үр дүнг тогтмол судалж ашиглах;
- Багшийн мэргэжлийн хөгжил, эрдэм шинжилгээ, олон улсын хамтын ажиллагаанд оролцох оролцоог бодлогоор дэмжих;
- Суралцагч, төгсөгч, ажил олгогчийн санал, сэтгэл ханамжийн судалгааг тогтмолжуулж, шийдвэр гаргалт болон хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах;
- Дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлж, төлөвлөлт–хэрэгжилт–үнэлгээ–сайжруулалтын мөчлөгийг тогтвортой хэрэгжүүлэх;
- Цахим сургалтын орчин, мэдээллийн сан, сургалтын хэрэглэгдэхүүн, номын сангийн нөөцийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Ил тод тайлагнал, мэдээллийн нээлттэй байдлыг хангаж, хөтөлбөрийн хэрэгжилт, чанарын үнэлгээний үр дүнг тогтмол олон нийтэд мэдээлэх.


3. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтад хийсэн шинжилгээний үр дүн

Монгол Улсын хэмжээнд 2025-2026 оны хичээлийн жилд 70 сургалтын байгууллага бүртгэлтэй үйл ажиллагаагаа явуулж 41,584 суралцагч суралцаж байна.

Өмчийн хэлбэр	Политехник	МБС	Бусад	Нийт	Суралцагч
Төрийн	31	8	3	42	29,531
Хувийн	9	19	0	28	12,053
Нийт	40	27	3	70	41,584

/Техникийн боловсрол: 5,670 суралцагч, Мэргэжлийн боловсрол: 35,324 суралцагч/

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн хувьд магадлан итгэмжлэлийн хугацаа хүчинтэй 39 байгууллага, процесс явагдаж байгаа 4, хугацаа дууссан 1, магадлан итгэмжлэгдээгүй 25 байгууллага байна.



Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарт 9 салбарын 105 мэргэжлийн чиглэлийн нийт 1096 хөтөлбөр хэрэгжиж байна. Үүнээс эрэлттэй, тэргүүлэх хөтөлбөр 286 буюу 26%-ийг эзэлж байна. 2025-2026 оны 2-р улирлын байдлаар дотоодын магадлан итгэмжлэлээр 82 сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэгдэж, 2 сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэхээс татгалзсан шийдвэр гарсан байна.

Мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын үр дүнгээр дотоод магадлан итгэмжлэлд нийт 82 хөтөлбөр (7.5%) хамрагдсанаас 69.5% нь мэргэжлийн, 30.5% нь техникийн боловсролын түвшинд байна.

ДОТООДОД МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨТӨЛБӨРИЙН ТОО
/МЭРГЭЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР/

(1-Р ХҮСНЭГТ)

Хөтөлбөрийн чиглэл	Тоо
01 Боловсрол	
02 Урлаг, хүмүүнлэг	3
03 Нийгмийн шинжлэх ухаан, мэдээлэл, сэтгүүл зүй	

04 Бизнес, удирдлага, эрх зүй	1
05 Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик	
06 Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд	2
07 Инженерчлэл, үйлдвэрлэл, боловсруулалт	50
08 Хөдөө аж ахуй, ой загасны аж ахуй, мал эмнэлзүй	7
09 Эрүүл мэнд нийгмийн хамгаалал	
10 Үйлчилгээ	19
Бүгд	82

Эдгээрээс эрэлттэй хөтөлбөр 33 буюу 42%, тэргүүлэх хөтөлбөр 14 буюу 18%, сайн дурын үндсэн дээр 31 буюу 40%-ийг магадлан итгэмжлүүлсэн байгаа нь хуульд заасан мэргэжлийн болон техникийн боловсролын эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэл нь 16.4%-ийн хэрэгжилттэй байна.



Мөн сургалтын хөтөлбөрийн шалгуур шаардлагын хэрэгжилтийн дундаж үнэлгээ 3.68 оноо буюу 92%-ийн түвшинд үнэлэгдсэн нь үндсэн шаардлагыг хангаж байгаа боловч зарим дэд үзүүлэлтүүдэд сайжруулалт шаардлагатай байгаа нь харагдсан. SHURE үнэлгээний бүтэц загварын шинжилгээгээр дэд үзүүлэлтийн үнэлгээ харилцан адилгүй (68%-96%) гарсан бөгөөд ялангуяа зайны болон цахим сургалтын технологийн нөхцөл, суралцагчийн шилжин суралцах болон хамтарсан хөтөлбөрөөр суралцах боломж, цахим мэдээллийн хүртээмж, судалгаа ба инновацийн дэмжлэг зэрэг үзүүлэлтүүд хамгийн бага үнэлгээтэй байв.



SURE загвараар гарсан шалгуур бүрийн үнэлгээний дундаж

k	B ₁										B ₂										B ₃															
	A ₁₁	A ₁₂	A ₁₃	A ₁₄	A ₁₅	A ₁₆	A ₁₇	A ₁₈	A ₁₉	A ₁₁₀	A ₁₁₁	A ₂₁	A ₂₂	A ₂₃	A ₂₄	A ₂₅	A ₂₆	A ₂₇	A ₂₈	A ₂₉	A ₂₁₀	A ₂₁₁	A ₂₁₂	A ₃₁	A ₃₂	A ₃₃	A ₃₄	A ₃₅	A ₃₆	A ₃₇	A ₃₈	A ₃₉				
1	0.67	0.67	1	1	1	1	0.67	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	0.67	0.67	0.33	1	1	1	1	1	1	1	1			
2	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	0.67	0.33	0.67	1	1	0.67	0.67	1	1	1	1	1		
3	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.33	1	0.67	1	0.67	0.67	0.67	1	1	1	0.67	1	0.67	1	0.67	0.33	1	0.67		
4	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	0.67	0.33	1	1	1	1	1	1	1	0.67	1	0.67		
5	1	1	1	1	1	1	1	0.67	1	0.67	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	0.67	1	0.67	
6	0.67	1	1	1	1	1	1	1	0.67	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	0.67	1	1	1	1	1	1	0.67	0.67	1	1	1	
7	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	0.33	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	
8	1	1	1	1	1	1	1	1	1	0.33	0.67	1	0.67	1	0.67	1	1	1	1	1	1	1	0.67	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
9	1	0.67	1	1	1	1	1	1	0.67	0.67	1	1	1	1	1	1	1	0.67	1	0.67	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
10	1	0.67	1	1	0.67	0.67	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	0.67	1	1	0.67	1	0.33	1	1	
11	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	0.33	1	0.67	1	1	1	1	1	0.67	1	1	0.67	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	
12	0.67	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	0.67	1	1	1	1	0.67	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	
13	1	0.67	1	1	1	1	1	1	0.67	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	
14	1	1	0.67	0.67	1	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	1	0.67	0.67	0.67	0.67	1	0.67	1	1	1	0.67	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
15	1	1	1	1	0.67	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	0.67	0.67	0.67	1	1	0.67	0.67	1	1	0.67	1	1	0.67	1	0.33
16	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	1	0.67	1	1	1	1	1	1	0.67	1	0.33	1	1	1	1	0.67	1	1	1	1	0.67	1	1	1	1	0.33	0.67	1	1	
17	1	0.67	0.67	0.67	0.67	0.67	1	0.67	1	1	1	1	1	0.67	1	0.33	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	0.67	1	1	1	0.33	0.67	1	1	
18	1	1	1	1	0.67	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	0.67	0.67	0.67	1	0.67	0.67	1	0.67	0.67	1	0.67	1	0.33	1	
19	0.67	1	0.67	1	0.67	0.67	1	1	1	0.67	0.67	1	0.67	0.67	0.67	0.67	1	0.67	1	1	0.67	1	0.67	1	0.67	1	0.67	0.67	0.67	1	0.67	1	1	1	1	
20	0.67	1	0.67	1	0.67	0.67	1	1	1	0.67	0.67	1	0.67	0.67	0.67	0.67	1	0.67	1	1	0.67	1	0.67	1	0.67	1	0.67	0.67	0.67	1	0.67	1	1	1	1	
21	0.67	1	1	1	0.67	1	0.33	1	0	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	0.33	1	0.67	1	1	1	1	0.67	1	1	0.67	1	1	1	1
22	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	0.67	1	1	0.33	1	1	1	1	0.67	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	1
23	0.67	0.67	0.33	0.67	0.67	0.67	0.67	1	1	0.67	0.67	1	1	1	1	0.33	0.67	1	0.67	1	0.67	1	0.67	1	0.67	1	0.67	1	1	1	0.67	0.67	1	1	0.67	
24	1	1	1	1	1	1	1	0.67	0.67	1	1	1	1	0.67	0.67	1	0.33	1	1	1	1	0.67	1	1	1	1	0.33	1	1	0.67	1	1	1	1	1	
25	0.67	1	1	1	0.67	1	1	0.67	0.67	1	1	0.67	1	0.67	1	0.33	0.67	0.67	1	0.67	1	0.67	1	1	0.67	1	1	1	1	1	0.33	0.67	1	1	1	
26	1	0.67	1	1	0.67	1	0.67	0.67	0.67	1	1	1	1	1	1	0.33	1	1	1	1	1	0.67	1	0.33	1	0.67	1	0.67	0.67	1	0.67	1	1	1	1	
27	1	0.67	1	1	0.67	1	0.67	0.67	0.67	1	1	1	1	1	1	0.33	1	1	1	1	1	0.67	1	0.33	1	0.67	1	0.67	0.67	1	0.67	1	1	1	1	
Q*(A _{ij})	0.9	0.89	0.91	0.95	0.85	0.93	0.9	0.9	0.83	0.81	0.93	0.96	0.93	0.9	0.9	0.91	1	0.88	0.96	0.95	0.93	0.83	0.69	0.93	0.88	0.91	0.83	1	0.85	0.77	1	0.89	1	0.89		
Q*(B _i)	1										1										1															

A ₄₁	B ₄						B ₅										B ₆					Q*(C)														
	A ₄₂	A ₄₃	A ₄₄	A ₄₅	A ₄₆	A ₄₇	A ₅₁	A ₅₂	A ₅₃	A ₅₄	A ₅₅	A ₅₆	A ₅₇	A ₅₈	A ₅₉	A ₅₁₀	A ₆₁	A ₆₂	A ₆₃	A ₆₄	A ₆₅															
0.67	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1		
1	1	0.67	0.67	0.33	0.67	1	1	1	1	0.67	1	1	0.67	0.67	0.67	0.67	1	0.67	0.67	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	0.67	1	1	1	1	
1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
1	1	0.67	0.67	0.33	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
1	1	1	0.67	0.67	1	1	1	1	1	1	1	1	0.67	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
1	1	1	0.67	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
1	0.67	1	0.67	0.67	1	1	0.67	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
1	1	0.67	1	0.33	1	1	1	1	1	1	1	1	0.67	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	0.67	0.67	1	1	0.67	1	1	1	1	1	
0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	
1	1	1	1	0.67	0.67	1	1	1	0.33	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
1	1	1	1	0.67	0.33	1	1	1	1	1	1	1	0.67	0.33	1	1	1	1	1	1	1	1	1	0.33	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
1	1	1	1	0.67	0.67	0.33	1	1	1	1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
1	1	1	1	0.67	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
1	1	1	1	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
1	1	1	1	0.67	0.67	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
0.9	0.89	0.93	0.84	0.75	0.88	0.99	0.9	0.95	0.94	0.94	0.86	0.86	0.91	0.86	0.88	0.98	0.88	0.84	0.99	0.93	0.81	Q*(C) = 1														
1						1										1																				

Чанарын шинжилгээний үр дүнгээр сургуулиуд дээр нийтлэг

нэмэгдүүлэх замаар уян хатан, хүртээмжтэй сургалтын орчныг бүрдүүлэх хэрэгтэй. Үүнтэй зэрэгцэн багшийн цахим болон мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх шаардлага өндөр байна.

Сургалтын орчин, материаллаг бааз, дотуур байр, лабораторийн нөхцөлийг сайжруулж, аюулгүй байдал, стандартын шаардлагыг бүрэн хангах нь сургалтын чанарт шууд нөлөөлөх чухал хүчин зүйл болох нь тогтоогдлоо. Санхүүжилтийн тогтвортой байдлыг хангахын тулд түншлэл, төсөл, өөрийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх хэрэгцээтэй байна.

Багшлах бүрэлдэхүүний хувьд судалгаа, инноваци, эрдэм шинжилгээний оролцоог нэмэгдүүлж, үнэлгээний ил тод, нотолгоонд суурилсан тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай байна. Багшийн ачааллыг оновчтой хуваарилах, хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлэх нь сургалтын чанарыг тогтвортой байлгах үндэс юм.

Суралцагчдад чиглэсэн үйлчилгээний хувьд сэтгэл зүйн дэмжлэг, дадлага, хөдөлмөр эрхлэлт, оролцоог нэмэгдүүлэх, тэгш хүртээмжийг хангах хэрэгцээ өндөр байна.

Ажил олгогч, төгсөгчийн оролцоог бүх түвшинд нэмэгдүүлэх нь бодит үр дүнд суурилсан хөтөлбөрийн сайжруулалтыг бий болгоно.

Чанарын баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлж, судалгаа, үнэлгээний үр дүнг хөтөлбөрийн шинэчлэлтэй уялдуулах нь тогтвортой хөгжилд чухал нөлөөтэй. Хөндлөнгийн үнэлгээ, төгсөгчийн мөшгөх судалгаа, хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийг ашиглан хөтөлбөрийг зах зээлийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй сайжруулах шаардлагатай байна.

Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагаас суралцагчдад чиглэсэн үйлчилгээ нь багшлах бүрэлдэхүүнд хамааралтай байгаа нь багшлах бүрэлдэхүүн сайн байх тусам суралцагчдад чиглэсэн үйлчилгээ сайжирдаг болох нь харагдаж байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Боловсролын Яаманд

- Мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, технологийн өөрчлөлттэй уялдуулан шинэчлэх бодлогын хүрээг тогтмолжуулах;
- Цахим болон зайны сургалтын дэд бүтэц, платформ, хүртээмжийг сайжруулах үндэсний түвшний хөрөнгө оруулалт, дэмжлэгийг нэмэгдүүлэх;
- Багшийн хөгжлийн бодлогыг бэхжүүлж, цахим ур чадвар, судалгаа-инновацийн чадамжийг хөгжүүлэх хөтөлбөрийг өргөжүүлэх;
- Сургалтын байгууллагын материаллаг бааз, лаборатори, дотуур байрны стандарт шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх бодлого боловсруулах;
- Ажил олгогчийн оролцоонд суурилсан хөтөлбөрийн шинэчлэлийн тогтолцоог үндэсний хэмжээнд дэмжих;

- Дотоод чанарын баталгаажуулалтын ажилтны орон тоог байгууллагын бүтцэд оруулж, нийгмийн асуудлыг нь шийдэж дэмжих;

Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлд

- Дотоод ба гадаад хөндлөнгийн үнэлгээний арга зүйг сайжруулах, нотолгоонд суурилсан үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх;
- Чанарын гарын авлага, стандарт, процессын уялдаа холбоог сайжруулж нэг мөр ойлголт бий болгох
- Үнэлгээ болон зөвлөмжийн уялдаа холбоог сайжруулж, үнэлгээний арга зүйг жигдрүүлэх;
- Зөвлөмжийн чанарыг бодит хэрэгжилтэд үзүүлэх нөлөө, байгууллагын үйл ажиллагаанд бий болгох өөрчлөлтийн шинж чанарт тулгуурлан сайжруулах;
- Зөвлөмжийн хэрэгжилтийн үр дүнг бодит баримт, ажиглалт, нотолгоонд суурилсан байдлаар шинжлэн судалж, үнэлгээний тогтолцоотой эргэх холбоотойгоор тасралтгүй сайжруулан хөгжүүлэх нь зүйтэй.

Сургалтын байгууллага, хөтөлбөр хэрэгжүүлэгчдэд (МБТБ-ын сургууль, багш нарт)

- Сургалтын хөтөлбөрөө хөдөлмөрийн зах зээл, ажил олгогчийн хэрэгцээнд үндэслэн тогтмол шинэчлэх, судалгаанд суурилсан төлөвлөлт хийх;
- Цахим сургалтын платформ, контент, үнэлгээний системийг бүрэн ашиглаж, сургалтыг уян хатан, хүртээмжтэй болгох;
- Багшийн цахим болон мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх дотоод системийг бий болгох;
- Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ (дадлага, зөвлөх үйлчилгээ, сэтгэл зүйн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлт)-ийг өргөжүүлэх;
- Судалгаа, инноваци, төгсөгчийн мөшгөх судалгаанд суурилсан хөтөлбөрийн сайжруулалтыг тогтмол хэрэгжүүлэх;
- Ажил олгогч, төгсөгч, түнш байгууллагын оролцоог бүх шатанд нэмэгдүүлэх;
- Багшийн ачааллыг оновчтой хуваарилж, хүний нөөцийн чадавхыг системтэй хөгжүүлэх;
- Сургалтын орчин, лаборатори, дотуур байрны чанар, аюулгүй байдлыг үе шаттай сайжруулах зэрэг санал зөвлөмжийг гаргалаа.

Судалгааг нэгтгэн боловсуулсан:

Судалгаа статистик хариуцсан ахлах мэргэжилтэн: Б.Соёлмаа

Судалгаа статистик хариуцсан мэргэжилтэн: Ц.Цэндмаа